



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 121

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Онцгой байдлын ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 10 нэрийн, нийт 315,423,798.00 (гурван зуун арван таван сая дөрвөн зуун хорин гурван мянга долоон зуун ерэн найм) төгрөгийн балансын үнэ, 5,286,275.50 (таван сая хоёр зуун наян зургаан мянга хоёр зуун далан таван төгрөг тавин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Онцгой байдлын ерөнхий газрын дарга хошууч генерал Г.Ариунбуян, харьяа газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001251

9-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн
124 дугаар тогтоолын хавсралт

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА БАЙГУУЛЛАГЫН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, БАЛАНСААС БАЛАНСАД
ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Шилжүүлэн авах байгууллагын нэр
Жаргалант сэргээн засах төв 113 дугаар ангид хөрөнгө:									
1	Тоёота Хайлюкс, улсын дугаар 92-51 УБЗ	2024	ш	1	180,000,000.00	180,000,000.00	3,000,000.00	177,000,000.00	Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төв 119-р анги
	хэсгийн дүн			1		180,000,000.00	3,000,000.00	177,000,000.00	
Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын хөрөнгө:									
2	Өлгүүр	2019	ш	1	481,500.00	481,500.00	248,775.00	232,725.00	Ар тал хангалтын 115-р анги
3	Ор 1.5м	2019	ш	1	880,000.00	880,000.00	454,666.46	425,333.54	
4	Тумбочка	2019	ш	1	240,000.00	240,000.00	124,000.00	116,000.00	
5	Буйдан Зхос	2019	ш	1	1,350,000.00	1,350,000.00	697,500.00	652,500.00	
6	Ширээ /сэтгүүлийн/	2019	ш	1	320,000.00	320,000.00	165,333.54	154,666.46	
7	Ширээ /дугуй/	2019	ш	1	380,000.00	380,000.00	196,000.54	183,999.46	
8	Контейнер 20тн	2021	ш	1	2,000,000.00	2,000,000.00	399,999.96	1,600,000.04	
9	Трансформатор цахилгааны шугам	2020	ш	1	50,000,000.00	50,000,000.00		50,000,000.00	
10	Цэвэр бохирын шугам	2020	м			79,772,298.00		79,772,298.00	

хэсгийн дүн		8		135,423,798.00	2,286,275.50	133,137,522.50	
НИЙТ ДҮН		9		315,423,798.00	5,286,275.50	310,137,522.50	
				(гурван зуун арван таван сая дөрвөн зуун хорин мянга долоон ерэн найм)	(таван сая хоёр зуун наян зургаан мянга хоёр зуун далан таван төгрөг тавин мөнгө)	(гурван зуун арван сая нэг зуун гучин долоон мянга таван зуун хорин хоёр төгрөг тавин мөнгө)	